

МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛСАН СОНГУУЛЬ: ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Д.Түмэнжаргал

Улс төрийн ухааны магистрант
(МУИС, Улс төр судлалын тэнхим)

Ардчилал нь хөгжлийн нэг чухал үзүүлэлт буюу шалгуур мөн. Ардчилсан сонгууль бол нэг талаас төрийн тэргүүн, парламент, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг хуульд заасан журмаар байгуулах арга хэрэгсэл, нөгөө талаас иргэд төрийг удирдах хэрэгт шууд оролцож байгаа үндсэн хэлбэр юм.

Манай орны хувьд сонголт эрт дээр үед байжээ. Харин ардчилсан сонгууль бол 1990 он хүртэл зөвхөн хэлбэрийн төдий л байсан юм. 1990 онд анхны ардчилсан чөлөөт сонгууль болж төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага Ардын Их Хурлыг сонгосон билээ. Сонгуулиар байгуулагдсан БНМАУ-ын Ардын Их Хурал 1991, 1992 оныг дамжин хуралдаж, 1992 оны 01-р сарын 13-нд Монгол улсын ардчилсан шинэ Үндсэн хуулийг баталж, тэрхүү хуулиар иргэдийн сонгуулийн эрх чөлөө, тухайлбал, сонгох, сонгогдох эрх чөлөөг жинхэнэ ёсоор нь хуульчлан баталгаажуулсан билээ.

Монгол улсын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа хууль тогтоох дээд байгууллага 1992 онд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, 1993 онд Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хууль, орон нутгийн сонгуулийн хуулийг батлан гаргасан юм. Эдгээр хуулийн дагуу монголчууд төрийн дээд байгууллагаа шууд, чөлөөтэй, ардчилсан зарчмаар дөрөв дөрвөн удаа сонгон ажиллуулаад байгаа бөгөөд монгол улсын иргэд сонгох, сонгогдох эрхээ тэгш эдэлж, сонгуульд чөлөөтэй оролцож, ухамсартай сонголт хийх бүрэн бололцоотой болсон байна. Энэ нь ардчилал бодит байдлаараа хэрэгжих нэг үндсэн баталгаа болжээ. Хэдийгээр манай орон ардчиллын замд эргэлт буцалтгүйгээр орж ардчилсан сонгуулийг явуулаад багагүй хугацаа өнгөрч байгаа боловч эерэг сөрөг олон хүчин зүйлийн улмаас нийгмийн амьдралд хойш тавилгүй шийдвэрлэвэл зохи нэн хурц асуудлууд тулгарсан хэвээр байгааг үгүйсгэх аргагүй юм.

Монгол дахь ардчилсан сонгуулийн талаарх бүхий л асуудлыг энэ өгүүлэлд авч үзэх боломжгүй тул УИХ, Ерөнхийлөгчийн дөрвөн удаагийн сонгуулийн онцлог, ололт, тулгарч буй бэрхшээл зэргийг, сонгогчдын оролцоо, сонгуулийн хуулийн хэрэгжилтээр дамжуулан нээж харуулахыг хичээлээ.

Нэг: 1992 оны УИХ-ын сонгуулийн гол ач холбогдол нь түүхэндээ анх удаа ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталж, түүгээрээ хүний эрх, эрх чөлөө, ардчилсан чөлөөт сонгуулийг хуульчлан баталгаажуулж, сонгуулийн тухай хуулийг баталж, нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд шилжин, ард түмэнд сонгох олон хувилбар, боломжийг олгосон оршино. Энэ нь нийгмийн хуучин байгуулал, улс төрийн тоталитар дэглэм, ноёрхогч ганц нам, түүний баримтлаж байсан албан ёсны марксист үзэл суртал, соёл, оюун санааны амьдралын тогтсон хуучин хэв загварыг халж өөрчлөхөд хүргэв. Түүний оронд зах зээлийн эдийн засаг, өмчийн олон хэлбэр, улс төрийн ардчилал, оюун санаа, үзэл сурталын олон ургальч байдалд тулгуурласан шинэ нийгмийг байгуулах эхлэлийг тавилаа. 1990 онд улс төрийн олон намууд анх удаа өрсөлдөн оролцсон шинэ, чөлөөт сонгууль болж өнгөрлөө. 1992 оны УИХ-ын сонгууль олон мандаттай мажоритар системээр явагдсан. Энэ сонгуулиар 8

нам, 2 эвсэл сонгуульд өрсөлдөн, нам эвслээс 275 нэр дэвшигч, бие даан нэр дэвшигч 18 хүн өрсөлдөж нийт нэр дэвшигчид нь 293-д хүрсэн нь монголын улс төрийн амьдралд ард түмний хувьд улс төрийн цоо шинэ үзэгдэл болсон юм. Мөн түүнчлэн нийт сонгогчдын 95,6 хувь нь оролцсон идэвхитэй анхны ардчилсан чөлөөт сонгууль болж байснаараа чухал ач холбогдолтой. 1996, 2000, 2004 оны УИХ-ын сонгуулиудыг нэг мандаттай тойрогт мажоритар системээр явуулсан. 1996 оны УИХ-ын сонгуулиар “Ардчилсан холбоо” эвсэл УИХ-д 50 суудал авч ялалт байгуулж манайд анх удаа засгийн эрх сонгуулийн зарчмаар, нэг улс төрийн хүчнээс нөгөөд тайван замаар шилжсэн. Энэ сонгуулиар нам эвслийн болон бие даан нэр дэвшигчдийн тоо нэмэгджээ. Тухайлбал нийт 302 нэр дэвшигчдийн 267 нь нам, эвслээс, 35 нь бие дааж нэр дэвшигчид байсан бөгөөд нийт 5 нам, 2 эвсэл оролцсон юм. Нийт бүртгүүлсэн сонгогчдын 92,1 хувь нь санал хураалтад сонгуульд оролцсон байна. Харин 2000 оны УИХ-ын сонгуулиар МАХН 72 суудал авч дахин засгийн эрхийг барих болсон. Энэ сонгуулиар ардчилсан хүчний ялагдсаны гол шалтгаан нь тэд хүчээ сарниулсан /эв нэгдэл, туршлага дутагдсан гэх зэрэг/ явдал юм. Нийт 13 нам, 3 эвсэл сонгуульд оролцож, 602 хүн нэрээ дэвшүүлсэн бөгөөд тэдний төлөө нийт сонгогчдын 82,4 хувь сонгуульд оролцож байжээ. 2004 оны УИХ-ын сонгуулиар түүхэндээ анх удаа их эвслийн Засгийн газар байгуулж улс төрийн хоёр том хүчин тэнцсэн байна.

Ардчилсан хүчин 2000 оны сонгуулийн дүнд дүгнэлт хийж хүчээ нэгтгэж чадсанаар энэ удаад ийм үр дүнд хүрсэн. Нийт 7 нам, 1 эвсэл сонгуульд оролцож, нам эвслээс 229 нэр дэвшигч, 15 бие даан нэр дэвшигчид сонгуульд оролцож нийт нэр дэвшигчдийн тоо 244 байсан. Сонгогчдын 82,2 хувь санал өгсөн байна.¹(СЕХ “Ардчилсан төрийн сонгуулийн товчоон” УБ., 2005 он). 1993, 1997, 2001, 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулиуд бүгд мажоритар системээр явагдсан билээ.

Дээрх сонгуулиудын үр дүнгээс дараахь дүгнэлт хийж болохоор байна.

1. 1992, 1996, 2000 болж өнгөрсөн парламентын ээлжит сонгуулиуд нь шилжилтийн үеийн өвөрмөц бэрхшээлтэй үед явагдсан. Учир нь Монголд болж өнгөрсөн сонгуулиуд нь тухайн үеийн улс төрийн сонгуульд оролцож байсан улс төрийн субъект, улс төрийн нам хүчин, электоратын төлөвшил, сонгуулийн кампани зохион байгуулах арга тактик нь дутуу дулимаг, сонгуульд бохир технологи хэрэглэсэн, эрх зүйн орчин нь сайн бүрдээгүй зэрэг хүчин зүйлүүдтэй ихээхэн холбоотой. Мөн 2004 онд болсон сонгууль ч энэ алдаа дутагдлыг давтсан бөгөөд бас л урьд урьдын сонгуулиудын нэгэн адил онцын ялгарах зүйлгүй болж өнгөрсөн юм.

2. Сонгуульд оролцсон нам, эвслийн байдлыг харвал 1992 оноос хойш болсон УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудаар манайх сонголт хийх боломжоор хангагдсан олон намын тогтолцоотой улс орон болох нь харагдаж байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд намууд эвсэл болон оролцох хандлага давамгайлж байна. Энэ нь сонгогчдод сонгох альтернатив боломжийг олгоод зогсоогүй намууд төлөвших хандлагатай болж, тэдний улс төрийн оролцоо сайжирч байгааг харуулж байна. Сонгуулийн тогтолцооноос улс төрийн намуудын төлөвшил, улмаар төрийн байгууллагын зохион байгуулалт, үйл ажиллагааны чадавхи ихээхэн шалтгаалдаг. Өөрийн орны өвөрмөц онцлогтой тохирсон дэлхий нийтээр өргөн дэлгэрсэн сонгуулийн тогтолцоог авч хэрэгжүүлж чадвал манай орны улс төрийн намууд, төрийн байгууллагуудын ажиллах чадвар эрс дээшлэх нь дамжиггүй. Ингэж чадахгүйгээс улс төрийн намуудын нийгэмд гүйцэтгэх үүрэг суларч, Улсын Их Хурлын түүнээс

улбаатайгаар төрийн бусад байгууллагын үйл ажиллагаа төдийлөн сайжирч боловсронгуй болж чадахгүй байна. Сонгуулийн кампанит ажил нь ч эмх замбараагүй, дэг журамгүй, бохир технологиор явж ирснийг үгүйсгэх аргагүй юм.

3. Ардчилсан сонгуулийн нэг чухал асуудал сонгогчдын сонгуульд оролцож байгаа оролцооны асуудал юм. Улс төрийн оролцоонд хайхрамжгүй ханддаг байдлыг “абсентейзм” гэж нэрлэдэг. Абсентейзм нь янз бүрийн түвшний сонгуульд санал өгөхөөс татгалзах явдал байдаг. Сонгогчид санал өгөх эрхээ хэрэгжүүлэхгүй байх нь олон хүчин зүйлээс хамааралтай. Зарим улс оронд сонгогчид зайлшгүй санал өгөх ёстой, түүнийг зөрчсөн тохиолдолд ял шийтгэл хүлээдэг байна. Жишээ нь: Австри улсад энэ тохиолдолд 4 долоо хоног ял эдлүүлдэг. Абсентейзмтэй Австри, Бельги, Голланд, Итали, Латин америкийн улсууд хүчтэй тэмцдэг.² (С.Базарпүрэв “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2005) Манай улс абсентейзмтэй эдгээр орон шиг хүчтэй тэмцэхгүй ч цаашдаа сонгогчдын боловсрол, ёс суртахуунд ахиц гаргах, тэдний сэтгэл зүйд улс төрийн ухамсрыг зөв төлөвшүүлэхэд түлхэц болохоор зүйлүүдийг хийх нь зүйтэй. Манай сонгогчдын сонгуульд оролцсон байдлыг өнгөрсөн нийт 8 сонгууль өөрөөр хэлбэл УИХ болон Ерөнхийлөгчийн дөрвөн удаагийн болсон сонгуулиудын дүнгээс харахад 1992, 1996 оны сонгуульд манай сонгогчид өндөр идэвхитэй 90-ээс дээш хувьтай оролцож байснаа дараа дараагийн сонгуулийн жилүүдэд буурсан үзүүлэлттэй байна. Эдгээр үйл явцад сонгогчдын улс төрийн үнэлэмж, үзэл бодол, сэтгэл зүй тогтворгүй хэлбэлзэнгүй байсаар ирсэн нь улс орны амьдрал өөрөө шилжилтийн шинж чанартай, нийгэм, эдийн засаг, улс төрийн салбар ихээхэн тогтвортой биш, хүн амын амьдралын төвшин өсөхгүй байсантай холбоотой юм. Улс төрийн намуудын нэр хүнд олон түмний дунд тогтворгүй хэлбэлзэлтэй байсан. Төрд ард түмний итгэх итгэл алдарч, сонгууль дөхөхөөр улс төрчдийн хийрхэл, нэр дэвшигчдийн хоосон амлалт, биелэшгүй мөрийн хөтөлбөрүүдээс сонгогчид маань залхаж эхэлсэн байв. Үүнийг удаа дараагийн сонгуулиудын үр дүн харуулж байна. Сонгогчид улс төрийн эрхээ эдэлж санал өгөх нь багассаар бүх нийтийн сонгууль болж чадахгүй байгаа нь энэхүү өгүүллийн хавсралт хүснэгтээс харагдаж байна. Хэрэв сонгогчдын дийлэнх нь оролцсон бол сонгуулийн эцсийн дүн ямар ч байж болох юм.

Сонгуульд санал өгсөн сонгогчдын тоо жил ирэх тусам багасаж байгаа нь чухам юутай холбоотой вэ? гэсэн асуудал гарч ирж байна. Үүнийг би дараахь хэд хэдэн хүчин зүйлүүдтэй холбоотой гэж үзэж байна. **Үүнд:**

1. Сонгуулиар гарч ирж байгаа төрийн түшээд хоосон амлаж элдэв бохир аргаар сонгуульд ялалт байгуулдаг. Сонгуулийн бохир технологи хэрэглэдэг. Тэд хэзээ ч амлалтаа бүрэн биелүүлж чаддаггүй зэрэг нь сонгогчдын итгэлийг алдахад хүргэж байна. Мөн авилгал, хээл хахууль дээд хүрсэн. Нөгөөтэйгүүр ажлын хариуцлага төрийн байгууллагуудын аль ч шатанд бараг байхгүй. Манай сонгуулийн хуулинд хариуцлага тооцох механизм байдаггүй. Аль ч намаас гарсан нэр дэвшигчидтэй тухайн нам эвсэл төрийн зүгээс хариуцлага тооцдог байх хэрэгтэй. Ямар нэг асуудал үүсэхэд бие биерүүгээ чихээд л өнгөрдөг. Үүнийг өнгөрсөн зуны МИ-8 нисдэг тэрэгээр осолдсон 15 хүний амь нас тод томруун харуулж өгсөн. УИХ-ын гишүүдийн үүрэг, хариуцлагад дорвитой ахиц гардаггүй. Парламентад ил тод ажил хэрэгч мэтгэлцээн байхгүй болсон, удирдлагын дээд түвшинд шүүмжлэлт, зарчимч байр сууриа алдсан, парламент нь тулга тойрсон хэрүүлийн танхим болон хувирчээ.

Түүнчлэн “Олон түмэн УИХ-ын үйл ажиллагаанд ерөнхийдөө тийм ч сэтгэл хангалуун биш байгаа нь судалгаануудаас мэдрэгдэж байна. Үндсэн хууль зөрчсөн нэг бус шийдвэр гаргаж байсан, эв нэгдэлтэй ажиллаж чадаагүй, ёс зүйгүй үйлдэл удаа дараа гаргаж, зарим гишүүд нь хууль зөрчсөн асуудалд холбогдсон зэрэг УИХ ба түүний гишүүдийн алдаа дутагдалтай үйлдлүүд нь иргэд сонгогчдын олонхи “УИХ ард түмнийг бүрэн төлөөлж ажилласангүй” гэж дүгнэхэд хүргэсэн. Мөн “Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй” гэгчээр УИХ-ын үйл ажиллагаанд гарч байгаа алдаа дутагдал нь жижиг, томоосоо үл хамааран нийгэмд хариуцлагагүй байдлыг дэвэргэж, ажил хэргийг унагаж, хөгжил дэвшилд саад болж, авилга, хээл хахууль, аливаа шударга бус зүйлийг УИХ ба түүний гишүүдтэй барьцах аргаар хаацайлан хамгаалах гэсэн оролдлогууд олшрон үржих хөрс суурийг бүрдүүлж байна. Тухайлбал, хамгийн сүүлд УИХ-ын үйл ажиллагаатай холбоотой мандаад байгаа шүүмжлэл бол “Эрүүгийн хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулахдаа төрийн албан хаагчтай хариуцлага алдсан албан тушаалтан ялаас зайлсхийх ноцтой үр дагавар бүхий алдаа болжээ.³(*Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын УИХ-ын хаврын Чуулганы нээлт дээр хэлсэн үг “Өнөөдөр хоёр маргаашийн үнэ цэнэтэй” УБ., 2008.04.07*)

Иргэд сонгогчид бодлогын шийдвэр, төр болон бизнесийн ажил үйлчилгээ бүх шатанд тал тохой татах явдал, авилга хээл хахуулиар хөдөлдөг, улс төр, бизнесийн бүлэглэлийн дохио зангаагаар явдаг хэмээн бухимдан шүүмжилцгээж байна. Ийм байдалд хүргэж буй шалтгаан нь хар амиа хоохойлох буюу эгоист үзлээс үүдэлтэй ашиг сонирхлын зөрчилд автах, албан тушаалаа урвуулан ашиглах явдал гэж судлаачид үзэж байна.

“Монголд сонирхлын зөрчил түгээмэл дэлгэрсэн, газар авах хандлагатай болсон” гэж саналаа илэрхийлсэн нь дээрх үндэслэлийг давхар нотолж байна. Энэ судалгаанд оролцогчдын 70-аад хувь нь УИХ-ын энэ удаагийн бүрэлдэхүүнийг сонирхлын зөрчилдөө хамгийн их хөтлөгдсөн байгууллага хэмээн нэрлээд түүний араас 50-иас дээш хувь авсан байгууллагуудыг жагсаавал газрын алба 69,8 хувь, гааль 65,1 хувь, Засгийн газрын танхим 57,0 хувь, яамдууд 54,3 хувь авчээ. Төр, түүний байгууллагуудын дүр төрх иргэд сонгогчдын нүдэнд ингэж харагдаж байна”. Эцсийн эцэст “ардчилсан нийгэм бол хууль хэрэгждэг, хуулинд захирагддаг нийгэм мөн” гэдгийг дахин сануулахад илүүдэхгүй”⁴(*Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын УИХ-ын хаврын Чуулганы нээлт дээр хэлсэн үг “Өнөөдөр хоёр маргаашийн үнэ цэнэтэй” УБ., 2008.04.07*)

Эдгээр хүчин зүйлийн нөлөөгөөр нийгэмд сөрөг үзэгдлүүд бий болж, ард түмний амьдрал доройтон, ажилгүйдэл, архидалт, хээл хахууль газар авч, шоу цэнгээний газрууд ихээр бий болон үүнийгээ дагаад нийгмийн эмх замбараагүй байдал, гэмт хэрэг өсөх хандлагатай байна. Мөн өргөн хэрэглээний барааны үнийн хөөрөгдөл ихсэж, ард түмний дунд бухимдал бий болж, бага цалин орлого нь ард иргэдийн амьдралд хүрэлцэхгүй, ажилгүйчүүд нь бүр ядуурч нийт хүн амын маань 36.1% нь ядуу, ажилгүйдэл 3.4%-тай гэсэн тоо гарч байна.⁵(*Өдрийн сонин., УБ., 2007.11.21 1 277 (2799)*)

Энэ тийм бага тоо биш ээ. Ер нь аливаа улсын ардчилсан төрийн үйл ажиллагаа сайжирч хөгжиж байгаагийн нэг үндсэн хэмжүүр нь хүн амын амьжиргааны түвшин гэж ойлгож болно. Нөгөө талаар нийгэмд эмх замбараагүй байдал газар авч, олон жижиг хөдөлгөөнүүд үүсэн бий болж, нийгэмд юм л бол өлсгөлөн зарлаж асуудлыг шийддэг үзэгдэл газар авсан нь ардчилал жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй гажуудаж байгааг харуулж байна.

2. Сонгууль болохоос нэг жилийн өмнө шат шатны төрийн байгууллагуудын ажл суларч сонгуулийн кампанит ажилд анхаарлаа төвлөрүүлж, төрийн албан тушаалтнууд намчирхах, нэг талыг барих нь илүүтэй ажиглагдаж байна. Ялангуяа сонгуулийн өмнө ч хойно ч намчирхах, төрийн ажил, намын ажил хоёр ялгарахгүй байдал орон нутгийн болоод төрийн захиргааны байгууллагуудад түгээмэл байна. Түүнчлэн орон нутгийн удирдлагууд нь нутаг усныхаа шинэ залуу боловсон хүчнийг ажлын байраар хангах, ажилтан, албан хаагчдыг сайжруулан сэлбэх асуудалд ихээхэн учир дутагдалтай ханддаг. Хуучин ажиллаж байгаа хүмүүс нь мэргэжлийн бус, ах, дүү, төрөл саднаа төрийн албанд ажиллуулсаар байна. Ийм учраас хөдөө орон нутагт ажлын хариуцлагагүй, халах тухай ойлголт байдаггүй нь нутаг орны хөгжилд сөргөөр нөлөөлөхөөс гадна төрийн ажлыг ихээр цалгардуулж хариуцлагын тогтолцоо алдагдаж байна.

3. Манай сонгогчдын өөрсдийнх нь улс төрийн ухамсар төлөвшөөгүй. Сонгогчдод ялангуяа хөдөө орон нутгийн сонгогчдын мэдлэг дутмаг, мэдээ мэдээлэл хомс, сонгогчдод улс төрийн сонголтыг зөв хийх, улс төрийн эрхээ эдлэх талаар нутгийн төр захиргааны байгууллагаас ухуулга сурталчилгаа хийдэггүй, энэ нь зөвхөн хөдөө орон нутагт ч бус манай улсын хэмжээгээр илэрч байгаа гол дутагдал юм. Энэхүү сонголтонд хариуцлагатай хандах нь ард түмэн, иргэд та бидний амьдралд эргээр ямар эерэг талтай гэдгийг сайтар ухуулаагүй байна. Иргэд буруу сонголт хийх буюу сонгуулийн эрхээ эдлэх тал дээр хайнга хандаж байгаа учраас сонгогчид ходоодоороо сонголт хийж өөрсдийнхөө эрх ашиг, сэтгэл зүй, үзэл бодол, байр сууриа золиосолдог нь сонгуулийн кампанит ажлын үеэрх сөрөг ухуулга сурталчилгаанд автдаг, жалга довоороо нутгархдаг, даган дуурайдаг, сонгуульд өрсөлдөж байгаа нам, нэр дэвшигчдийн хөтөлбөр, бодлого үйл ажиллагааг бодитойг шүүн тунгаах мэдлэг, боловсрол, соёл, чадвар ихээхэн дутмаг байгаатай холбоотой юм. Энд өчүүхэн миний бие дээр дурьдсан хугацаанд улс төрийн сонгуулиудын үйл явц, үр дүнг харлуулж харуулахыг зориогүй, гажиг бурууг тодорхой сонгогчдод нялаахыг оролдсонгүй. “Монгол улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх бөгөөд сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэсэн Үндсэн хуулийн заалтыг дахин сануулъя. Иргэд сонгогчид энэхүү эрхээ эдлэхдээ дөрвөн минут зарцуулах боловч улс орныхоо дөрвийн дөрвөн жилийн хувь заяаг тодорхойлно. Учир иймд иргэд Та бүхний сонголт хариуцлагатай, бас ухаалаг байх учиртай. Ингэж чадваас бид хөгжлийн боломжоо ашиглаж, хүрэх зорилгодоо ойртоно. Эс чадваас хоцрогдол, ядуурал, ажилгүйдэл, бухимдлын битүү тойрогтоо эргэлдсээр л байх болно”⁶(Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын УИХ-ын хаврын Чуулганы нээлт дээр хэлсэн үг “Өнөөдөр хоёр маргаашийн үнэ цэнэтэй” УБ., 2008.04.07)

Хэдийгээр сонгогчдын тоо цөөрч, сонгуульд оролцох идэвхитэй оролцоо нь буурсан ч 1990 оноос өмнөх үеийн сонгогчдын сэтгэл зүй, ухамсар, боловсрол улс төрийн сонголт хийх чадвар нь алхам алхмаар дээшилж нилээдгүй дэвшилтэт байдалд хүрснийг хэлэх хэрэгтэй. Ерөнхийлөгчийн сонгуульд сонголт хийхдээ хувь хүний төрх илүү нөлөөлдөг гэдгийг санах хэрэгтэй. Хэдийгээр намаас нэр дэвшиж байгаа ч Ерөнхийлөгч болсныхоо дараа бүх ард түмнийг төлөөлнө. Намын эрх ашиг гэхээсээ илүү төрийн эрх ашгийн төлөө ажиллах хүнийг сонгох хэрэгтэй. Мөн хувь хүний шударга байдал, аль нэг намын нөлөөлөлд автахгүй байх чадвартай, мэдлэгтэй, хэсэг бүлгийн эрх ашиг гэхээсээ илүү нийтийн эрх ашгийг өмнөө тавьж ажиллаж чадах зэрэг

шалгууруудыг л их чухалчлах нь зүйтэй юм. Ард түмэн олон шалгуураар сайн сонголт хийх эрх үүрэгтэй. Харамсалтай нь манай сонгогчид энэ эрхээ бүрэн ашиглаж чадахгүй байна. Сонгуульд оролцох насны бүх сонгогчид хамрагдвал жинхэнэ утгаараа сонгууль бүх нийтийн болж чадна. Гэтэл ардчилсан сонгуулийн бүх нийтийн үндсэн зарчим нь алдагдаж байна. Гэхдээ саяхан явуулсан санал асуулгад оролцогчдын 73,9 хувь нь 2004 оны сонголтондоо “сэтгэл хангалуун бус” байна гэсэн хариулт өгсөн. Энэ нь иргэд сонгогчид маань өнгөрсөн сонголтондоо шүүмжлэлтэй хандаж ирээдүйн сонголт цэгнэн ухаалаг сонголт хийх нэг алхам нь болж байна хэмээн ойлгож болох юм.

Хоёр: Сонгогчдын оролцоотой холбоотой бас нэг чухал асуудал нь хүчингүй саналын хуудасны тооны асуудал юм. Анхны буюу 1992 оны УИХ-ын сонгуулиар улсын хэмжээнд 62243 саналын хуудас хүчингүй болж байсан нь нийт сонгогчдын 6,0%-ийг эзэлж байв. 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар улсын хэмжээнд нийт 36019 саналын хуудас хүчингүй болж байсан. Нэг тойрог 34000 мянган сонгогчидтой байсан бол дээрх хүчингүй болсон саналын хуудас нь тэднээс 2000-иар илүү буюу 3,5%-ийн санал тус тус хүчингүй болж байсан.⁷(СЕХ, *Ардчилсан төрийн сонгуулийн товчоон. УБ., 2005 он*) Энэ нь юуг харуулж байна вэ? гэвэл манай сонгогчдын ухамсар сайн төлөвшөөгүй, тэдний боловсролын түвшин доогуур, сонгуулийн эрхээ эдлэхдээ хариуцлагагүй ханддаг зэрэг шалтгаануудаас үүдэлтэй. Гэхдээ дараа дараагийн УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулиудаар хүчингүй болсон саналын хуудасны тоо багассан нь сайшаалтай хэрэг юм.

Гурав: Манайх шиг хүн ам цөөнтэй орон сонгуулийн тойргоо олон жижиг хэсэгт хуваах нь зохимжгүй юм. Энэ нэг талаас жалга довны үзэл, нутгархах хандлагыг дэвэргэж, популистуудын сонгогдох магадлалыг ихэсгэж, халаас нимгэн ч мэдлэг чадвартай, Монголын хөгжилд дорвитой зүйл хийж чадахаар хүмүүсийг парламентад оруулах боломжийг хааж байна. Мөнгөтэй л хүн төрд гардаг жишиг тогтоод байна. Тэднийг өрсөлдүүлэхдээ элдэв шоугаар бус, шударга ярилцлага, мэтгэлцээнээр, мэдлэг чадвараар нь гаргаж ирэх хэрэгтэй. Ер нь ардчилсан сонгуулийн бас нэг гол үзүүлэлт нь элдэв шоу, мөнгөөр гарах биш чадвараараа, дуу хоолойгоороо сонгуульд ялалт байгуулах явдал юм. Энэ нь ардчилсан сонгуулийн шударга байх зарчмыг алдагдуулж, сонгогчдын улс төрийн соёл бүрэн төлөвшөөгүйг харуулж байна. Мөн 76 тойрог нь манай улсын цөөн хүн амыг сарниулан эв нэгдэлгүй болгоход нөлөөлж болзошгүй юм. Аль болохоор нэгдмэл эв эеэ хичээсэн байдлыг хангахад хууль тогтоомжоо чиглүүлэх нь зүйтэй.

Дөрөв: Ер нь шударга сонгууль гэдгийг олон улсын жишгээр авч үзэх юм бол сонгуулийг зохион байгуулж байгаа байгууллагад хэр итгэл үзүүлэх вэ? гэдгээр хэмждэг. Иймд төрийн өмнө онцгой үүрэг хүлээсэн сонгуулийн төв байгууллага сонгуультай холбоотой бүхий л асуудлыг хуулийг дагуу тодорхой болгож, сонгогчдын саналыг хэрхэн тоолох, бүртгэх талаар иргэдэд нэг мөр ойлголт өгөх, сонгуулийн хуулийг сурталчлан таниулах ажлыг дорвитой хийх хэрэгтэй байна. СЕХ-ноос нэр дэвшигчид болон нам, эвслүүд сонгуульд зарцуулах мөнгөний тоог өндөр тогтоож өгсөн нь сонгогчдын саналыг мөнгөөр худалдаж авах, нэр дэвшигчид болон нам, эвслүүд хандив авах нэрээр хахуульд өртөх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байна.

Мөн сонгууль явуулах эрх бүхий байгууллагад итгэл үзүүлж болох боломжтой гэсэн итгэлтэй байх нь сонгууль шударга явагдахын нэг үндэс юм. Тийм итгэлтэй байхын тулд олон улсын жишигт сонгуулийг зохион байгуулагч байгууллагын бүрэлдэхүүнийг хоёр янзаар бүрдүүлдэг. 1. Мэргэжлийн, маш өндөр түвшний, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээс бүрддэг. 2. Намуудын

тэгш төлөөллөөс бүрдсэн байх жишээтэй. Бүх шатны хороо, хэсгийг намуудын тэгш төлөөллөөр бүрдүүлдэг. Аль алиных нь төлөөлөл тэнцүү байсан тохиолдолд маргаан бага гардаг. Гэтэл манайд механизм нь тодорхой бус байсаар байна. Сонгуулийн ерөнхий хороо маш хариуцлагатай ажиллах ёстой. Хариуцлагатай ажиллуулахын тулд механизмыг нь зөв бүрдүүлэх хэрэгтэй. СЕХ-ны бүрэлдэхүүнийг томилдог ямар нэг шалгуур үзүүлэлт байхгүй. Тухайн үеийн албан тушаалыг харгалзан томилдог. Ихэнхидээ нэг намын хүмүүс байдгийг ч үгүйсгэхгүй. Тэд ихээхэн будлиан тарьдаг. Ийм учраас Сонгуулийг зохион байгуулж явуулдаг эрх бүхий байгууллагын дотоод зохион байгуулалт, түүний бүрэлдэхүүнийг томилохдоо зохих шалгуур үзүүлэлтүүдийг үндэслэн томилон ажиллуулах мөн олон намуудын төлөөллөөс оруулж ажиллуулах нь зүйтэй. Ингэж чадвал алдаа гаргахгүй ажиллаж чадна. Сонгуулийн хэсэг хороодод бөөн будлиан луйвар боллоо гэсэн суртал нэвтрүүлгүүд сонгуулийн үеэр маш хүчтэй хийгддэг. Хамгийн гол нь төрийн хэвийн үйл ажиллагааг хангах нь чухал.

Тав: Сонгуулийн шинэ хууль нь бүх шатны байгууллагуудын сонгуулийг боловсронгуй болгох ач холбогдолтой юм. Үүнтэй холбогдуулан сонгуулийн шинэ хуулийн агуулгыг тодорхойлох талаар дараахь хэдэн зүйлийг дурьдах нь зүйтэй гэж үзэв. УИХ-ын сонгуулийн хуульд бага ч болов өөрчлөлт оруулсан нь зарим зүйл заалтын хувьд ихээхэн ач холбогдолтой ч зарим зүйл заалт амьдрал дээр хэрэгжих нь бага байгааг ч хэлэхгүй өнгөрч болохгүй юм. Үүнд:

1. УИХ-ын сонгуулийн хуулийн нэгдүгээр бүлгийн 4.2, 2-р бүлгийн 12.1-д заасан заалтанд УИХ-ын 76 гишүүнийг сонгох сонгуулийг олон мандаттай тойргоор зохион байгуулж явуулна” хэмээн заасан нь зөв зүйтэй болсон. Яагаад гэвэл УИХ-ын гишүүдийн өрсөлдөх чадвар, үнэнч шударгаар өрсөлдөх боломж олгоод зогсохгүй, ард түмэн олон хувилбараас зөв сонголт хийх боломжтой болж байна. Гэхдээ энэ заалтад чухам хэдэн тойрогтой байх вэ? бүх аймаг хотоо нийлүүлээд улс даяар нэг том тойрог байх юмуу? Эсвэл ямар зохион байгуулалтаар хэдэн тойрогт хуваахаа тодорхой тусгаагүй нь учир дутагдалтай заалт болжээ. Үүнийг тодруулах нь зүйтэй. Урьд жилүүдийн сонгуулиар тойргийг сонгогчдын тооны хувьд ихээхэн зөрүүтэй байгуулж байсан юм.
2. УИХ-ын сонгуулийн хуулийн зүйл заалтуудын заримыг цаг хугацааны хувьд ихээхэн богино хугацаанд болгосон байна. Тухайлбал 1-р бүлгийн 8.1-д “Сонгуулийн санал авах өдрөөс 75-аас доошгүй хоногийг гэснийг 45-аас доошгүй хоногийн гэж өөрчилсөн”, 2-р бүлгийн 12-р зүйлд тойрог байгуулах хугацааг 70 хоног байсныг 6 сараас доошгүй хугацаанд гэж өөрчилсөн”, харин хэсгийг 13.1-ээр санал авах өдрөөс 65 хоногийн өмнө гэснийг 35-аас доошгүй хоногийн гэж өөрчилсөн, 13.2-т нэг хэсэг нь суманд 1500 сонгогчтой байна гэснийг 2000 сонгогчидтой болгосон. Харин энэ хуулийн 16-р зүйлийн 16.1-ээр тойргийн хороог санал авах өдрөөс 60 хоногийн өмнө байгуулна гэснийг 40-өөс доошгүй хоногийн өмнө, 17-р зүйлийн 17.1-д тойргийн салбар хороог санал авах өдрөөс 35-аас доошгүй хоногийн өмнө гэснийг 30-аас доошгүй хоногийн өмнө, 18-р зүйлийн 18.1-д хэсгийн хороог санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө гэснийг 30-аас доошгүй хоногийн өмнө гэх мэтчилэн цаг хугацааны хувьд наашлуулсан эдгээр заалтууд нь энэ хуулинд тийм ч чухал, тулгамдсан зайлшгүй өөрчлөх ёстой асуудал биш. Ингэж өөрчилсөн нь энэ хуулинд тийм ч бодитой чухал өөрчлөлт болохгүй гэж үзэж байна.
3. 37-р зүйлийн 37.6 заалт нь зөрчигддөг. Сонгуулийн сурталчилгаа эхлэхээр эмх замбараагүй байдал үүсэж, энд тэндгүй ухуулга сурталчилгааны самбар, зурагт хуудсууд наасан байдаг. Үүнийг цэгцлэх талаар хуульчилсан ч тэр бүр хэрэгжиж чаддаггүй. Энэ тал дээр бас анхаарах нь зүйтэй.
4. 7-р бүлгийн 37.16-р заалт нь Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн сурталчилгааны тэнцвэрт байдалд олон нийтийн оролцоотойгоор хяналт тавих асуудалд хяналт сул тавьдагаас сонгуулийн сурталчилгаа, хэвлэл мэдээллийн тэнцвэргүй байдал тухайн сонгуулиудын дүнд нөлөөлдөг. Сонгуулийн үйл ажиллагааны талаар мэдээлэхдээ тэнцвэртэй, шударга байх зарчмуудыг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд жигд хангаж чадахгүй байна. Ерөнхийлөгчийн сонгуулийн үед энэ байдал илүү ажиглагддаг. Сонгуулийг зөв шударга, соёлтой явуулахад

хариуцлагатай, ёс зүйтэй сэтгүүл зүй чухал үүрэгтэй. Хэвлэл мэдээллээр бие биеэ “гүтгэх, доромжлох, намнах” гэсэн явцуу ашиг сонирхлоос үүдэлтэй өмнөх сонгуулиудын “хар PR” нийгмийн сэтгэл зүйд муугаар нөлөөлж байна. Ийм учраас дараа дараагийн сонгуульд хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэргэжлийн өндөр түвшинд аль нэг нам, нэр дэвшигч гэж туйлшралгүйгээр ажиллахад ихээхэн анхаарах хэрэгтэй.

5. УИХ-ын сонгуулийн хуулийн 4-р бүлгийн 20.1 дэх заалт нь амьдралд хэрэгждэггүй байв. Зарим сум, дүүрэг, баг хорооны Засаг дарга тус тусын нутаг дэвсгэрт оршин суугаа сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсгийн хороонд гаргаж өгдөггүй тохиолдол нь тухайн сонгууль болохоос өмнө сонгуулийн материал нь дутуу дулимаг, бодитой биш, түүнчлэн дээр нь электрон хэлбэрт оруулаагүй зэрэг нь хэсгийн хорооны ажилд хүндрэл учруулдаг. Мөн энэ хуулийн 46-р зүйлд заасан “сонгуулийн ажиглагч” нартай холбоотой асуудал. Эдгээр заалттай холбоотой асуудлууд нь 2005 оны УИХ-ын нөхөн сонгуулийн 65-р тойргийн 60-р хэсгийн хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байх явцад хэрэгждэггүйгээс ихээхэн хүндрэл учирч хэсгийн хорооны гишүүд өөрсдөө уг нэрийг жагсаалтыг компьютерт оруулж цэгцэлсэн юм. Сонгуулийн ажиглагч нар улс төрийн мэдлэг өндөртэй байх чухал гэдэг нь тухайн үеийн сонгуулиар ажиглагч нарын зарим нь мэдлэг дутмагаас хэсгийн хорооны ажилд саад учруулж хий хоосон хардаж, нэрийн жагсаалттай холбоотой ойлголт муугаас “задгай”-д бичиж байгаа сонгогчдын нэрсийг хүртэл мэдэхгүй сонгууль хэвийн явуулах ажиллагааг сааруулж, хэсгийн хорооны ажлыг хөндлөнгөөс санаатайгаар саатуулах оролдлого хүртэл хийж байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй нь. Миний ажиллаж байсан хэсэгт ажиглагч нарын ёс зүй болоод улс төрийн мэдлэг нь сул дээр нь нэрийн жагсаалтыг хуулийн дагуу хэсгийн хороонд гаргаж өгөх ажил туйлын хангалтгүй байсан юм. Мөн 20.—д⁸(*Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хууль, 1992 он*) зааснаар сум, дүүргийн Засаг дарга сонгогчдын нэрийн жагсаалтыг жил тутам гаргаж хэвших хэрэгтэй. Ингэвэл адаглаад ямар нэг будлиан гарах нь бага байна.

Зургаа: Ерөнхийлөгчийн сонгуулийн тогтолцооны талаар ноцтой яригддаг зүйл бараг үгүй байдаг. 1990 оны парламентын сонгууль мажоритар тогтолцооны тусгай зарчмыг голлосон холимог хэлбэрээр, 1992 оны УИХ-ын сонгууль олон мандаттай мажоритар системээр, 1996, 2000, 2004 оны УИХ-ын сонгууль нэг мандаттай мажоритар системээр, 1993, 1997, 2001, 2005 оны Ерөнхийлөгчийн сонгуулиуд мажоритар системээр явагдсан. Үүнээс үзэхэд манай сонгуулиудын ихэнхи нь мажоритар системээр явагдаж байв. Манай оронд хэрэглэгдэж байгаа эл систем нь парламентын засаглалыг хэрэгжүүлэх үйл явцад өөрийн зарим эерэг нөлөөгөө үзүүлсэн ч бас хүндрэлтэй асуудлыг бий болгосон. Энэ системээр сонгогдсон УИХ-ын гишүүд нийт улс орны ашиг сонирхлыг төлөөлөхөөс гадна өөрийн нам болон тойргийн сонгогчдын итгэл найдвар хүсэл зоригийг илэрхийлдэг.

Ялангуяа улс орны амин чухал асуудал болох төсвийг хэлэлцэх явцад тойргийн сонирхол нилээд давамгайлах байдлаар илэрдэг. Үүнээс болж парламентат ёсны нийтлэг зарчмыг алдагдуулах, үзэл бодол, байр суурийн хувьд зөрчилдөх зэрэг сөрөг таагүй байдлыг бий болгодог. Манай орны хувьд пропорциональ системийг шууд сонгоход зарим бэрхшээл, УИХ-д хэт олон төлөвшөөгүй намууд орж, түүний хууль тогтоох хүч, чадамжийг сулруулах, парламентад тогтворгүй байдал үүсгэх талтай. Харин сонгуулийн холимог хувилбар нь намын системийн төлөвшилтөнд яаж нөлөөлөхийг одоогоор урьдчилан хэлэхэд хүндрэлтэй. Гэвч тусгай зарчмын онцлогийг үндэслэн зарим зүйлийг тодруулж болно. Манай улс засаглалын хэлбэрийн хувьд парламентын засаглалтай, нэг танхимтай парламенттай, гишүүдийн тоо нь бусад оронтой харьцуулахад цөөн.

Монголд парламентын засаглалыг бодитой төвшинд ажиллуулах улс төр, эрх зүйн механизм одоогоор бас л гүйцэд бүрдээгүй байгаа нөхцөлд пропорциональ системийг шууд авч ашиглах нь улс төрийн үр дагаврын хувьд ноцтой байж болох талтай. Эндээс үзвэл намын системийг цаашид төлөвшүүлэх талаасаа пропорциональ систем хэрэгтэй боловч өнөөгийн намуудын хөгжлийн төвшин, парламентын үйл ажиллагааны чадвар,

бүрдэлтээс үүсэж болзошгүй зарим бэрхшээлийг тооцож үзвэл одоогоор уг системийг сонгох нь арай эртэдсэн хэрэг байж болзошгүй. Хэрэв сонгуулийн мажоритар тогтолцоог хэвээр нь хадгалбал түүний сөрөг үр дагавруудыг арилгахад чиглэсэн алхмуудыг хийх хэрэгтэй. Мөн сонгуулийн дүн нь ямагт сонгуулиас сонгуулийн хооронд савлагаатай гарч байна. Сонгуулийн хуулийг улам боловсронгуй болгох, сонгогчдын ухамсар, соёлтой холбоотой өсөлтийн бэрхшээл ч багагүй байна. Гэхдээ мажоритар систем нь сонгогчид намыг нь биш хувь хүнийг нь сонгодог учир хөдөө орон нутгийн сонгогчдод чухал ач холбогдолтой, нэр дэвшигчийн хувийн шинж чанарыг үнэлж цэгнэх бололцоотой, хэн олон санал авсан нь ялагч болдог тул сонгогчдод ойлгоход хялбар, энгийн, ойлгомжтой зэрэг нь манай сонгогчдын улс төрийн боловсролын төвшингөөс шалтгаалан шилжилтийн өнөөгийн нөхцөлд илүү ойр дөт харагдаж байгааг хэлэх хэрэгтэй. Дэлхийн улс орнуудад сонгууль явуулдаг 150 шахам арга байдаг. Үүнээс үзэхэд улс бүр өөрийн онцлогт тохирсон сонгуулийн тогтолцоог авах нь зүйтэй байх. Сонгуулийн тодорхой нэг тогтолцоог сонгохын өмнө түүний онцлог, түүнд нийцсэн улс төрийн өвөрмөц бодит орчин нөхцлийн бүрдэлт, гарах үр дагавар зэрэг цогц олон хүчин зүйлийг урьдчилан нарийн тооцож үзэх нь хамгийн чухал юм. Мөн үүний зэрэгцээ заавал сонгуулийн системийг тохирохгүй болохгүй байна гэж яаран солихоосоо илүү тухайн системийн сул талыг засаж сайжруулж, саармагжуулах оновчтой арга механизмыг өөрсдөө олж хайн улам төгөлдөржүүлэх нь зүйтэй юм.

Ардчилсан сонгууль нь бүх нийтийн, тэгш, саналыг нууцаар гаргах гэсэн эрх зүйн тусгай зарчим, сонгууль өрсөлдөөнтэй байх, тогтмол байх, олонхийг хамарсан, бүрэн төгс байх гэх мэт эдгээр зарчмууд нь ардчилсан сонгуулийн гол үндсэн зарчмууд юм. Манай оронд 1990 оноос өмнө сонгууль хэлбэрийн төдий явагдаж байсан. 1990 оноос хойш ардчилсан чөлөөт сонгууль явагдаж ирсэн боловч сонгуулийн үндсэн зарчмуудыг бүрэн гүйцэд баримтлаагүй учраас алдаа онооо, дутагдал гарсаар байжээ. Энэ нь ардчилсан сонгууль явуулах үйл явцын шилжилтийн шинжтэй байсантай холбоотой юм.

Эцэст нь сонгуулийг шударга, зөв, ил тод, соёлтой явуулахад төрийн ба төрийн бус байгууллага, улс төрийн намууд, нэр дэвшигчид, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд тус тусдаа хариуцлага хүлээдэг тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Мөн баг хороо, сум, дүүргээс эхлээд засаг захиргааны бүх нэгж, шатанд иргэдийн бүртгэл судалгааг чанаржуулж, сонгогчдын үүрэг хариуцлагыг сануулж, соёлтой ухаалаг хандлагыг төлөвшүүлэх үүргээ төр мартаж болохгүй. Түүнчлэн сонгуульд нэр дэвшигчдэд нэр дэвших шалгуур үзүүлэлт, цензурыг тодорхой болгож улс төрийн өндөр мэдлэг боловсрол, чадвартай удирдагчдыг сонгох нөхцөл бололцоог бүрдүүлэх нь чухал байна. Мөн сонгогчдод сонгуулийн шинэ хуулийн талаар сайтар сурталчлан хэдэн тойрогтой, хэдэн мандаттай, саналын хуудсанд тэмдэглэгээг яаж хийх талаар сайн мэдээлэл өгөн сонгогчдын нэрийн жагсаалтын маргаан будлианыг эцэслэн бүртгэл мэдээллийг алдаа мадаггүй болгож чадваас сонгууль зөв, шударга болох эхлэл нь тавигдана.

Цаашид төрийн ардчилсан сонгууль улам боловсронгуй болох бололцоо бүрэн байгаа билээ.

Ашигласан болон иш татсан материал

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он
2. Монгол улсын УИХ-ын сонгуулийн хууль, 1993
3. Монгол улсын УИХ-ын сонгуулийн хууль, 2005 он
4. А.Жамбал “Монгол дахь сонгууль, сонгуулийн систем” УБ., 2002 он
5. Ред. Ц.Ганболд /МУИС/ “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2002 он
6. СЕХ. “Ардчилсан төрийн сонгуулийн товчоон” УБ., 2005 он
7. С.Базарпүрэв “Улс төрийн шинжлэх ухаан” УБ., 2005
8. Монгол улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын УИХ-ын хаврын Чуулганы нээлт дээр хэлсэн үг “Өнөөдөр хоёр маргаашийн үнэ цэнэтэй” УБ., 2008.04.07